

“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН 2022 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2022.12.05

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2021 он	Хүрэх түвшин 2022 он	Биелэлт
Зорилт 1. Эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хандлагыг нэмэгдүүлэх					
1	Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон магистр, докторын сургалтад төлөвлөлтийн дагуу хамруулах	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	73%	75%	2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн нийт 170 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 30 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна. Дархлаажуулалтын сувилагчийн мэргэжил олгох сургалтад байгууллагын зардлаар 5 сувилагч, Эрүүл мэндийн яамны санхүүжилтээр 5 сувилагч суралцсан. БОЭТ-ийн “Ерөнхий мэргэшил судлал”-аар тайлант хугацаанд 1 резидент эмч суралцаж байна. “Эрчимт эмчилгээний сувилахуй”, Яаралтай тусламжийн сувилахуй” чиглэлээр төгсөлтийн дараах сувилахуйн сургалтыг 2022 оны 10 сарын 01-ээс эхлэн 16 сувилагч элсэн суралцаж байна. Докторын зэрэгтэй эмч 0,2%, магистрын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтэн 8%-тай байна. Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь нийт эмч мэргэжилтний 12,9% байгаа нь өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн, төгсөлтийн дараах сургалтад хамруулахаар төлөвлөсөн эмч мэргэжилтний эзлэх хувь 73% байна. <i>Хэрэгжилт 97,3 хувь</i>
2	Орон нутагт нэн шаардлагатай байгаа мэргэшүүлэх сургалтад хамрагдахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	75%	80%	Орон нутагт нэн шаардлагатай компьютертомограф соронзон давтамж бүхий дүрс оношилгоо судлал, ангиограф судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 1 эмч, тархины судасны бичлэг судлал 1 эмч, хүүхдийн мэс засал судлалаар 1 эмч төрийн сангийн санхүүжилтээр тус, тус суралцаж байна. Нэн шаардлагатай мэргэжил эзэмшсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 75% байна. <i>Хэрэгжилт 93,7%</i>
3	Сургалт, эрдэм шинжилгээний ажлыг хийх боломжоор хангах, судалгаа шинжилгээний ажил хийх, өгүүлэл нийтлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Судалгаа, шинжилгээний ажлын тоо, үр дүн	4	4	Дэлхийн эмч нарын өдөр болон Олон улсын сувилагчдын эрхийг хамгаалах өдрийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжийн дагуу Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя, Сувилахуйн бие даасан байдал-Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулъя уриатайгаар зохион байгуулж ажиллалаа. Тус үйл ажиллагааны хүрээнд эмч, сувилагчдын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, судалгааны аргазүйн ур чадварыг сайжруулах, нотолгоонд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж эрдэм

					<p>шинжилгээний хурлын I шатанд эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн 104 илтгэл, II шатанд 62 илтгэл хэлэлцэгдсэн. Эрдэм шинжилгээний хурал нь нийгмийн эрүүл мэнд болон эмнэлзүй гэсэн 2 хэлбэрээр зохион байгуулагдаж нийт 12 илтгэл шалгарсан. Судалгааны арга зүйн чадавхжуулах сургалтыг АШУҮИС-тай хамтран цахимаар зохион байгуулж нийт 68 эмч, сувилагчдыг хамруулсан. 2022 оны эмч, сувилагчдын эрдэм шинжилгээний хурлын онцлог нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр илүү олон асуудал дэвшүүлсэн, цар тахлын үеийн эмчилгээ, оношилгоо, урьдчилан сэргийлэлт, бэлэн байдал, хариу арга хэмжээг дүгнэсэн, сургамж үлдээсэн гэдгээрээ өмнөх он жилүүдээс онцлог байлаа. Эрдэм шинжилгээний хурлаас шалгарсан 15 илтгэлийг “Анагаах увидас” сэтгүүлд хэвлэн нийтийн хүртээл болгосон. Тус сэтгүүлийг 300 ширхэг хэвлүүлэхэд 5,0 сая төгрөгийн санхүүжилтийг “Эмч” хөтөлбөрөөс олгосон.</p> <p><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
		Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17.5%	18%	<p>Нийт 104 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн судалгаа шинжилгээний ажил хийж, 62 илтгэл эрдэм шинжилгээний хуралд тавьсан байна. Мөн бодлогын түвшинд 2 удаагийн цахим судалгаа хийгдэж танилцуулсан. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,5% өссөн үзүүлэлтэй байна.</p> <p><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
4	Мэргэжлийн зэрэг ахиулахад дэмжлэг үзүүлэх	Мэргэжлийн зэрэгтэй эмчийн эзлэх хувь	23%	24%	<p>Тайлант хугацаанд нийт 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг шинээр хамгаалснаас зөвлөх зэрэг 1, тэргүүлэх зэрэг 8, ахлах зэрэг 12 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамгаалсан нь өмнөх оноос 28,8%-аар нэмэгдэж 26,7%-ийг эзэлж байна.</p> <p><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
5	Өндөр хөгжилтэй оронд мэргэжил дээшлүүлэх, магистр, докторт суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Боловсролын зэрэгтэй эмчийн хувь	11,1%	11,8%	<p>Эрүүл мэндийн салбар байгууллагуудын эмч, эрүүл мэндийн ажилтнуудаас боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь 11,8% байна. Тайлант хугацаанд Анагаах ухааны магистрын зэрэгтэй 8 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төгсөж, 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн суралцаж байна.</p> <p><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
6	Гадаад улсад бэлтгэгдсэн эмч, мэргэжилтэн өөрийн мэдлэг, туршлагаа түгээн дэлгэрүүлэхийг дэмжих	Мэдлэг, туршлагаа дэлгэрүүлсэн эмч, мэргэжилтний тоо	2	2	<p>Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч, Солонгос улсад зохион байгуулагдсан олон улсын дотрын эмч нарын сургалтад 1 эмч Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг нийт 6 эмч, мэргэжилтнийг хамрууллаа.</p> <p><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>

7	Эмч, эмнэлгийн мэргэжилтний гадаад хэлний мэдлэгийн түвшнийг үе шаттайгаар дээшлүүлэх, суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж дэмжлэг үзүүлэх	Гадаад хэлний мэдлэгийн түвшин, дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18,6%	19.6%	<p>Эмнэлгийн залуу мэргэжилтний англи хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор БОЭТ-ийн 15, ЭМГ, ӨЭМТ-ийн 15 нийт 30 эрүүл мэндийн ажилтныг англи хэлний дунд шатны сургалтад хамруулсан. Гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлсэн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх 19,6%-д хүрсэн ахисан үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: center;"><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
8	Эмнэлгийн практик шинэ төрлийн эмчилгээ нэвтрүүлэх	Эмнэлгийн практикт нэвтрүүлсэн шинэ төрлийн эмчилгээ үйлчилгээний тоо	15	17	<p>Тайлант хугацаанд лавлагаа шатлалд 35 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ашиглалт 92% болж өмнөх оноос 2%-аар нэмэгдсэн. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хөнгөвчлөх, уламжлалтын тасагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар 140 сая төгрөгийн 17 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. - Эрүүл мэндийн дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмжөөр хангагдан 2862 хнд эрт илрүүлэг үзлэг хийгдсэн. - Баян-өндөр мед нэгдсэн эмнэлэг нь төвөнхийн дуран, <u>биомикроскопи</u>, 28 үзүүлэлт бүхий <u>гематологийн анализатор</u>, хүүхдийн харааг <u>ретиноскопигоор шинжлэх</u>, ходоодны дурангаар ходоодны салстын хавдрыг хуулах эмчилгээг нэвтрүүлж, <u>“Медозонс БМ”</u> аппаратаар 160 гаруй хүнд озон эмчилгээ хийсэн. - <u>“Мажаа”</u> клиник эмнэлэг нь <u>Diers 4D форметрик</u> аппаратаар 268 хүний <u>нугалмын гулсалт</u>, эргэлт, суулт, <u>муруйлтын зургийг</u> богино хугацаанд өндөр нарийвчлалтайгаар авч үйлчилсэн. <u>Нугалмын хөдөлгөөнт засал</u> эмчилгээг давтан тоогоор нийт 1027 хүнд хийсэн ба эдгээрээс 25% нь давтан эмчилгээ хийлгэсэн байна. - <u>“Эрхэст-оргил”</u> клиник нь <u>унтуулгын</u> аппарат болон мэс заслын дуран шинээр нэвтрүүлсэн. Сонсгол бууралтын <u>түвшин</u> тогтоож, дэвшилтэт технологийн хиймэл оюун ухаан бүхий сонсголын аппарат програмчлан тохируулах, хяналт, засвар үйлчилгээг хийж ажилласан. - Орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг <u>билиметр</u> болон <u>УВЧ</u> аппаратаар хангасан. - <u>Жаргалант суманд</u> орон нутгийн хөгжлийн сангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын өрөөг бүрэн тохижуулсан. <p>“Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим програмд үзлэгийн бүртгэл хөтлөх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичихэд ашиглах зөвөрийн 20</p>

					ширхэг таблетаар хангасан. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
9	Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, хэрэглэх аргад суралцахад нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, дэмжлэг үзүүлэх	Суралцсан эрүүл мэндийн ажилтны тоо	10	10	Төрөлжсөн мэргэшлээр 3-6 сарын хугацаатай сургалтад компьютертомограф соронзон давтамж бүхий дүрс оношилгоо судлал, ангиограф судсан дотуурх эмчилгээ оношилгоо судлалаар Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөс 1 эмч, тархины судасны бичлэг судлал 1 эмч, үндсэн мэргэшлийн 2 жилийн хугацаатай сургалтад төрийн сангийн санхүүжилтээр чих хамар хоолой, мэдээгүйжүүлэг 3 эмч, дүрс оношилгоо судлалаар 2 их эмч, эмч хөтөлбөрийн санхүүжилтээр бөөр судлалаар 1 эмч суралцаж байна. Хүүхдийн мэс засал, эх, ураг судлалаар нийт 2 эмч суралцаж байна. Тайлант хугацаанд орчин үеийн дэвшилтэт технологи ашиглах, хэрэглэх аргад 10 эмч суралцсан байна. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
10	Эрүүл мэндийн байгууллагууд цахим тоног төхөөрөмж ашиглан суралцах, эмчилгээ оношилгоонд ашиглах боломж бүрдүүлэх	Цахим тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо	1	1	Бүсийн оношилгооны төвд суурилагдсан зайн оношилгооны телемедициний хурлын төхөөрөмжөөр 134 хурал, сургалт семинар зохион байгуулагдаж 512 холбогдох удирдлага эмч, мэргэжилтэн хамрагдсан. Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн санхүүжилтээр 39 тоног төхөөрөмж нийлүүлэгдэн, хэрэгжилт 100%-тай байна. Тайлант хугацаанд БОЭТ-ийн телемедициний алсын зайн оношилгоо, техник тоног төхөөрөмжөөр уушги, зүрх судасны өвчний эмгэгийн оношилгоо, эмчилгээний чиглэлээр Улсын нэгдүгээр төв эмнэлэгтэй 2 удаа холбогдож оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс Lifesize программыг нэвтрүүлж, нэвтрэх эрхийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн нь телемедицинийг гар утаснаасаа алсын зайн оношилгоо эмчилгээнд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Жаргалант сумын эрүүл мэндийн төвд тус төсөл үргэлжлэн хэрэгжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд мобайл тусламж үйлчилгээг 165 өрхөд 355 хүнийг хамруулсан. Эрүүл мэндийн яаманд мобайл технологийн төсөлд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын судалгаа болон тус төсөлд хамрагдах 2 өрхийн эрүүл мэндийн төвийн судалгааг хүргүүлсэн. байна. "Цахим Эрдэнэт-1" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг 20 ширхэг таблетаар хангаснаар түргэн тусламжийн дуудлага болон өрхийн гэрийн эргэлтээр тусламж үйлчилгээ үзүүлсэн эмч тухайн иргэний өвчний түүхийн мэдээллийг цахим системээс харах, үзлэгийн бүртгэл шивэлт хийх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухай бүрт нь бичиж хүлээгдэл, чирэгдлийг бууруулсан бөгөөд сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн компьютерын хангалт 95%-д хүрсэн. Цахим тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо-10 <i>Хэрэгжилт 100 хувь</i>

11	Гадаад, дотоодын эмч нартай ажил мэргэжлийн туршлага солилцох, ажлын байр сэлгэн ажиллах нөхцөлийг бий болгох	Сэлгэн ажилласан эмчийн тоо	3	3	<p>Тайлант хугацаанд 71 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг лавлагаа шатлалд болон анхан шатлалд сэлгэн ажиллуулсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хүүхдийн тасагт өрхийн эрүүл мэндийн төв болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас нийт 62 эмч, сувилагчийг ажлын байранд сэлгэн ажиллуулсан. - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн тоног төхөөрөмжийн инженерийг хувийн хэвшлийн эмнэлгүүдэд болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гэрээгээр ажиллаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж үйлчилсэн. - Хувийн хэвшлийн ор бүхий 10 клиник 8 эмч зүйчийг гэрээгээр сэлгэн ажиллуулж байна. - Дадлагажуулах 4 удаагийн сургалтад 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Үүнд: - Улаанбаатар хотын Интерсайнс ХХК-аас лабораторийн тоног төхөөрөмж, шинжилгээ авах, хяналтын тест тавих сургалтад 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн - Цахимаар МЮКЭС-ээс гадаад хяналт, биохими, цусны дэлгэрэнгүй, тохиргоо үзэх сургалтыг лабораторийн нэгдсэн тасгийн эмч, лаборант нарт - БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас хүлээх авах 5 тасгийн 20 эмч, сувилагч нарт - БОЭТ-ийн лабораторийн нэгдсэн тасгаас түргэвчилсэн тест авах арга зүйн сургалтад 35 эмч, сувилагчид тус тус зохион байгуулсан байна. <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 100 хувь</i></p>
12	Анагаах ухааны төрөлжсөн номын сан байгуулах	Номын сангийн тоо	2	-	<p>Эрүүл мэндийн газрын Анагаах ухааны төрөлжсөн номын санд Англи, Орос, Монгол хэлний 1000 орчим номын <u>баяжилт</u> хийж, “Цахим номын сан” үүлэн технологид суурилсан номын сангийн автоматжуулалтын олон улсын программ “<u>МОНКОХА</u>” программыг нэвтрүүлсэн.</p> <p style="text-align: right;"><i>Хэрэгжилт 70 хувь</i></p>
13	Нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөлдөх уулзалтыг жил бүр зохион байгуулах	Уулзалт, зөвлөгөөний тоо, үр дүн	1	1	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн болон эрүүл мэндийн салбаруудын удирдлага нийт 70 гаруй хүний төлөөлөл оролцлоо. - Анагаахын Шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 80 жилийн ой хүрээнд “Багш шавийн уулзалт”-ыг зохион байгуулж, 110 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. - Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 13 хүний бүрэлдэхүүнтэй баг хамт олон ирж эрүүл мэндийн салбарын 110 эмч эмнэлгийн мэргэжилтэнтэй уулзаж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн үйл ажиллагааг танилцуулан эмч, мэргэжилтнүүд тулгамдаж буй асуудлаа танилцуулж санал солилцсон. - Монгол Улсын Мэдээгүйжүүлэгч эмч нарын “Хагалгаа тойрны анагаах

					ухаан” сэдэвт зөвлөгөөн Орхон аймагт зохион байгуулагдаж, 105 эмч мэргэжилтэн оролцсон. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
14	Эрүүл мэндийн ажилтны ёс зүйг хувь хүний хандлагад тулгуурлан төлөвшүүлэх сургалтыг зохион байгуулах	Ёс зүйн зөрчил гараагүй байх	-	2	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь 1 ёс зүйн салбар хороо, 2 хэсгийн хороо, 6 багийг арга зүйгээр ханган ажилласан. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд, сувилал тус бүр ёс зүйн харилцаа хандлагын чиглэлээр сургагч багш бэлтгэж сургагч багш бүр байгууллага тус бүртээ соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж ажилласан. Тайлант хугацаанд 39 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1024 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос “Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт 2 багц цагийн сургалтад 285 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссоос Орхон аймгийн эрүүл мэндийн салбарын удирдлагууд болон эмч, мэргэжилтнүүдэд “Хүний эрхэд суурилсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ” 1 багц цагийн кредит бүхий 5 өдрийн сургалтыг зохион байгуулж нийт 145 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. Тайлант хугацаанд ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд гомдол ирээгүй. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
15	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, байгууллагын хөгжил удирдлага төлөвлөлт зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор үйлчлүүлэгчид, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг авах, судалгааны дүнг үндэслэн арга хэмжээг зохион байгуулах	Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн тоо, үр дүн	80%	85%	Аймгийн Засаг даргын 2022 оны А/105 дугаар захирамжаар Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дэргэд хэрэгжүүлж байгаа “Сэтгэлд нийцсэн хөтөч” үйлчилгээ ажиллуулахад дэмжлэг үзүүлж, 6 хөтөч сувилагчийн цалин, нэг удаагийн хэрэгсэлд 35,2 сая төгрөгийг шийдвэрлэн ажиллуулснаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж 92,5% болж өмнөх оноос 17%-иар нэмэгдэж, иргэдийн тодорхойгүй, мэдээлэлгүй, ойлгомжгүй байдал 88,2 хувиар багассан. ЭМС-ын 2022 оны А/346 дугаар тушаалаар үйлчлүүлэгчээс болон эмнэлгийн ажилчдаас авах стэгэл ханамжийг судалгааг ЭМБ-ууд өөрсдийн онцлогт тохирсон байдлаар авахаар заасан. Үүний дагуу ЭМБ-ууд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг амбулатори, хэвтэн эмчлүүлэх хэсэгт QR кодоор шууд уншуулж авсан. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж өмнөх оноос БОЭТ, ӨЭМТ, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын тохижилт ая тухтай байдалд 98-99%, харилцаа хандлагын байдалд ӨЭМТ-д 90%-дээш, БОЭТ-д 85%, хувийн хэвшлийн байгууллагуудад 95%-иас дээш, эмчилгээ, оношилгооны чанарт БОЭТ, Эрдэнэт Медикал эмнэлгүүдэд 90%-иас дээш үнэлгээг өгсөн нь лавлагаа шатлалын эмнэлгүүдэд оношилгооны чадавх нэмэгдсэн, өндөр өртөгтэй хагалгааг орон нутагт хийснээр иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэнийг харуулж байна. БОЭТ нь сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтийг үндэслэн ажилчдыг тогтвор суурьшилтай

					ажиллуулах нийгмийн баталгааг дэмжих зорилгоор шинээр орон сууц авах 30 ажилтанд 20,0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон болон гүйцэтгэлээр санхүүжих болсон нь ажилчдын сэтгэл ханамжид нөлөөлж, 95%-иас дээш байна. Эрүүл мэндийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлтээс харахад БОЭТ, өрхийн эрүүл мэндийн төвийн ажилчид <u>КОВИД-19</u> цар тахал буурсантай холбоотойгоор ажилчдын ажлын ачаалал өмнөх оноос буурч ажилчдын сэтгэл ханамж өмнөх оныхтой харьцуулбал 1,2%-иар нэмэгдсэн байна. <u>Эрдэнэт медиал эмнэлэг</u> болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн ажилчдын сэтгэл ханамж 85%-тай байна. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
16	Эрүүл мэндийн байгууллагуудын менежментийг сайжруулах, манлайллыг хөгжүүлэх чиглэлээр сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Сургалтад хамрагдсан байгууллагын тоо	4	4	<ul style="list-style-type: none"> - Тайлант хугацаанд “Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001-2015” стандартыг Эрүүл мэндийн газар нэвтрүүлж гэрчилгээг гардан авсан. Эрүүл мэндийн газар нь “Чанарын ISO 9001-2015” стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 6 удаагийн сургалтад хамрагдан ЭМГ-ын дарга болон 23 албан хаагч байгууллагын дотоод аудитын сургалтад хамрагдаж, гэрчилгээ гардан авсан. - Эрүүл мэндийн байгууллагын хагас бие даасан засаглал, гүйцэтгэлээр санхүүжих чиглэлээр сургалтад <u>эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага</u> болон холбогдох эмч мэргэжилтэн 51 хүн хамрагдсан. - Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, ДЭМБ-тай хамтран эмнэлгүүдийн хагас бие даасан засаглалыг хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн 2 удаагийн сургалтад Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн удирдлагын баг, тасгийн эрхлэгч нарыг хамруулсан. - Эмэгтэйчүүдийн манлайлал багц цагийн сургалтад 4 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
<i>Хэрэгжилтийн дундаж 100%</i>					
Зорилт 2. Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлнэ.					
17	Эрүүл мэндийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилтны хувь, эмчлэн эрүүлжүүлсэн ажлын үр дүн	91%	92% .	Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон Эрүүл мэндийн газрын 687 ажилтан урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар орж байгаагаас 92% нь хамрагдсан. Тус хөтөлбөрийн хүрээнд 10 сая төгрөгийн санхүүжилтээр Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 40-өөс дээш насны 330 ажилтныг хавдрын маркерын шинжилгээнд хамруулснаас 3 ажилтан өөрчлөлттэй гарсныг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээсэн. Мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтан байхгүй байна. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
18	Эрүүл мэндийн салбарын ажилчдын	Тохижуулсан танхимын тоо	10	12	Тайлант хугацаанд Ачит эмнэлэг өргөтөл барьж засварлаж ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чийрэгжүүлэлт болон амрах өрөө,

	чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэлт болон амрах өрөөг засаж, тохижуулах				гал тогооны өрөө засаж тохижуулсан. 2022 онд нийт 14 эрүүл мэндийн байгууллага шинээр эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан бөгөөд тус байгууллагууд ажилчдын амрах өрөөг тохижуулсан байна. БОЭТ-ийн Дотрын тасгийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар засварласан. Мөн ажиллагсдыг ширээний теннис тоглох боломжоор хангасан байна. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
19	Гэр болон түрээсийн орон сууцанд хамруулах	Хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	14	14	Эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан аймгийн ЗДТГ-аас түрээсийн орон сууцаар хангагдсан байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь үр бүтээлтэй олон жил ажиллаж байгаа 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медиал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
20	Ахмад эмч, сувилагч нарыг мэргэжлийн сургалтад хамруулж цаг үеийн мэдээллээр ханган хамтран эрүүл мэндийн арга хэмжээ зохион байгуулах	Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь	10%	10,2%	Эрүүл мэндийн байгууллагаас тэтгэвэрт гарсан 75-аас дээш насны “Буурлын чагнуур” ТББ-ын 15 гишүүн сайн дурын ажилтнаар бэлтгэгдэн гэрийн асаргаа сувилгаа болон сэтгэл зүй тусламж үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд тус сайн дурын ажилтанг цаг үеийн мэдээллээр хангаж ажилласан. Сургалт мэдээлэлд хамрагдсан хувь 10,16% <i>Хэрэгжилт 99,6 хувь</i>
21	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа коронавируст халдвар /ковид/-ын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг хангах, дэмжлэг үзүүлэх	Нийгмийн ноцтой байдлын үед ялангуяа ковидын цар тахлын үеийн хариу арга хэмжээнд ажиллаж буй эмч эмнэлгийн ажилчдын дэмжлэгт хамрагдсан хувь	25%	0	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын үеэр аймгийн шуурхай штабт 2022 оны эхний улирлыг дуустал ажилласан эмч, мэргэжилтнүүдэд Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу ажлын бус цагаар болон амралтын өдрүүдэд ажилласан мэргэжилтнүүдэд илүү цагаар бодож олгосон. Нийт 6 хүнд илүү цагийн 312000 төгрөгийг олгосон байна. <i>Хэрэгжилт 100 хувь</i>
22	Жил бүр аймгийн “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-ыг	Шалгарсан эрүүл мэндийн ажилтны тоо	1	-	Тайлан хугацаанд төрийн дээд одон медалиар 6, ардын хувьсгалын 100 жилийн ойн медалиар 15 Засгийн газрын шагналаар 53, орон нутгийн шагналаар 68, бусад 10 эмч, эмнэлгийн мэргэжилтэн тус тус шагнагдсан.

	сонгон шалгаруулж, урамшуулдаг байх				Шагнал урамшуулалд нийт эрүүл мэндийн ажилтны 10,4% хамрагдсан байна. 2022 оны жилийн эцсийн ажлыг дүгнэж “Тэргүүний эрүүл мэндийн ажилтан”-аар “Мөнхсүндрэл” ӨЭМТ-ийн их эмч Г.Хишигжаргал, Шилдэг өрхөөр Мэндцэцэн ӨЭМТ тус тус шалгарсан. <i>Хэрэгжилт 70%</i>
Хэрэгжилтийн дундаж -96,9 хувь					
Нийт хэрэгжилтийн дундаж хувь 96,9 хувь					

“ЭМЧ” ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2021 он/	2022 он	2024 онд хүрэх түвшин	Тайлбар
<i>Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадвар, төлөвшил, ёс зүй, хандлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:</i>					
1	Төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	71.4%	73%	82%	2022-2023 онд төрийн сангийн санхүүжилт болон хувийн зардлаар үндсэн болон төрөлжсөн мэргэшил, мэргэжил дээшлүүлэх сургалтад 79 эмч, 91 сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн нийт 170 эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн суралцаж байгаагаас төрийн сангийн санхүүжилтээр 15 эмч, 12 сувилагч, тусгай мэргэжилтэн, нийт 30 суралцаж байна. Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь нийт эмч мэргэжилтний 12,9% байгаа нь өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн, төгсөлтийн дараах сургалтад хамруулахаар төлөвлөсөн эмч мэргэжилтнээс төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь 73% байна.
2	Мэргэжлийн зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /ахлах, тэргүүлэх/	22.1%	23%	26%	2022 онд нийт 21 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг шинээр хамгаалснаас зөвлөх зэрэг 1, тэргүүлэх зэрэг 8, ахлах зэрэг 12 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамгаалсан нь өмнөх оноос 28,8%-аар нэмэгдэж 26,7%-ийг эзэлж байна.
3	Боловсролын зэрэгтэй эмч, эмнэлгийн мэргэжилтний хувь /магистр, доктор/	11%	11.1%	13%	Эрүүл мэндийн салбар байгууллагуудын эмч, эрүүл мэндийн ажилтнуудаас боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь 11.1% байна. Тайлант хугацаанд Анагаах ухааны магистрт 3 эмч суралцаж байна.
4	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	22.7%	23%	25%	Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч, Япон улсад төгсөлтийн дараах сувилахуйн сургалтад 3 сувилагчийг тус тус хамруулсан. Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь 0,3% өссөн үзүүлэлттэй байна.
5	Гадаад хэлний түвшин дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	18.4%	19.6%	20%	Эмнэлгийн залуу мэргэжилтний англи хэлний чадварыг дээшлүүлэх зорилгоор Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 15, Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвийн 15 нийт 30 эрүүл мэндийн ажилтныг англи хэлний дунд шатны сургалтад хамруулсан. Гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлсэн нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх 19,6%-д хүрсэн ахисан үзүүлэлттэй байна.
6	Судалгаа, шинжилгээний ажил хийсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь	17,5%	18%	20%	Нийт 104 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн судалгаа шинжилгээний ажил хийж, 62 илтгэлийн эрдэм шинжилгээний хуралд тавьсан байна. Мөн бодлогын түвшинд 2 удаагийн цахим судалгаа хийгдэж танилцуулсан. Энэ нь нийт эмч эмнэлгийн мэргэжилтний 18%-ийг эзэлж 0,5%-аар нэмэгдсэн

					байна.
7	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлсэн, өгүүлэл нийтлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	26	30	20	Австри улсад зохион байгуулагдсан олон улсын мэдрэлийн эмч нарын сургалтад 1 эмч, АНУ-д зохион байгуулагдсан клиник эмгэг судлаачдын холбооны лаборатори оношилгооны сургалтад 1 эмч, Солонгос улсад зохион байгуулагдсан олон улсын дотрын эмч нарын сургалтад 1 эмч хамрагдаж тус бүр илтгэл хэлэлцүүлсэн. УГТЭ-ээс зохион байгуулсан эрдэм шинжилгээний хуралд 2 илтгэл, Монголын дурангийн мэс заслын эмч нарын 6-р чуулганд 1 илтгэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний чуулганд 1 илтгэл, Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд дотоодын эрдэм шинжилгээний хуралд нийт 8 илтгэл тус тус илтгэгдсэн байна. Анагаах увидас сэтгүүлд 15 илтгэл хэвлэн нийтлүүлсэн.
8	Шинэ төрлийн эмчилгээ, үйлчилгээ нэвтрүүлсэн тоо	3	17	12	Тайлант хугацаанд лавлагаа шатлалд 35 нэр төрлийн өндөр өртөг бүхий техник тоног төхөөрөмж, 17 нэр төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлж, ашиглалт 92% болж өмнөх оноос 2%-аар нэмэгдсэн. Тухайлбал: - Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хөнгөвчлөх, уламжлалтын тасагт орон нутгийн хөрөнгө оруулалтаар 140 сая төгрөгийн 17 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан. - Эрүүл мэндийн дэмжих төвд улсын төсвийн 1,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 34 нэр тоног төхөөрөмжөөр хангагдан 2862 хнд эрт илрүүлэг үзлэг хийгдсэн. - Баян-өндөр <u>мед нэгдсэн эмнэлэг нь төвөнхийн дуран, биомикроскопи, 28 үзүүлэлт бүхий гематологийн анализатор, хүүхдийн харааг ретиноскопигоор шинжлэх, ходоодны дурангаар ходоодны салстын хавдрыг хуулах эмчилгээг нэвтрүүлж, “Медозонс БМ” аппаратаар 160 гаруй хүнд озон эмчилгээ хийсэн.</u> - “Мажаа” клиник эмнэлэг нь <u>Diers 4D форметрик аппаратаар 268 хүний нугалмын гулсалт, эргэлт, суулт, муруйлтын зургийг богино хугацаанд өндөр нарийвчлалтайгаар авч үйлчилсэн. Нугалмын хөдөлгөөнт засал эмчилгээг давтан тоогоор нийт 1027 хүнд хийсэн ба эдгээрээс 25% нь давтан эмчилгээ хийлгэсэн байна.</u> - “Эрхэст-оргил” клиник нь <u>унтуулгын аппарат болон мэс заслын дуран шинээр нэвтрүүлсэн. Сонсгол бууралтын түвшин тогтоож, дэвшилтэт технологийн хиймэл оюун ухаан бүхий сонсголын аппарат програмчлан тохируулах, хяналт, засвар үйлчилгээг хийж ажилласан.</u> - Орон нутгийн 50,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 өрхийн эрүүл мэндийн төвийг <u>билиметр болон УВЧ аппаратаар хангасан.</u> - <u>Жаргалант суманд орон нутгийн хөгжлийн сангийн 16,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 5 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, орон нутгийн 10,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургалтын өрөөг бүрэн тохижуулсан.</u>

					- “Цахим Эрдэнэт-1” төслийн хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн гэрийн дуудлага, гэрийн эргэлт, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн түргэн тусламжийн дуудлагын үед цахим програмд үзлэгийн бүртгэл хөтлөх, хөнгөлөлттэй эмийн жорыг тухайн газарт нь бичихэд ашиглах зөөврийн 20 ширхэг таблетаар хангасан.
9	Ёс зүйн сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	2191	2224	2000	ЭМГ-ын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо нь ЭМЯ болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтран ёс зүй, харилцаа хандлагын чиглэлээр 38 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 2224 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамруулж, өмнөх онтой харьцуулахад сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 1,5%-аар нэмэгдэж, гомдол бүртгэгдээгүй байна.
10	Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын эзлэх хувь	7.4%	0	0	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол бүртгэгдээгүй. Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 90 хүсэлт, өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн. Эрүүл мэндийн газарт ирүүлсэн хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 40.7%-аар буурсан, гомдол бүртгэгдээгүй байна. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл АЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэж мэдээлэгдэж, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.
<i>Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд</i>					
11	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмч, эмнэлгийн ажиллагсдын эзлэх хувь /40+ насны ажилчдыг	91%	92%	90%	Эрүүл мэндийн салбарын ажилчдын 92% нь урьдчилан сэргийлэх үзлэгт насны ангиллаар хамрагдсан. Мөн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн, БОЭТ, ЭМГ-ын 40-өөс дээш насны 330 ажилчдыг 7 төрлийн хавдрын маркерийн шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний санхүүжилт болох 10,0 сая төгрөгийг “Эмч” хөтөлбөрөөс шийдвэрлэсэн. Мэргэжлээс шалтгаалах өвчний асуудал эрхэлсэн төв байгууллагад илгээж онош тодруулах шаардлагатай ажилтан байхгүй байна.
12	Эмчлэн эрүүлжүүлсэн эрүүл мэндийн ажилтны тоо	24.1/408/	10.2/188/	43,7/740/	Урьдчилан сэргийлэх үзлэгээр нэмэлт шинжилгээ хийлгэх, эчлүүлэх шаардлагатай 188 ажилтныг эмчлэн эрүүлжүүлсэн.
13	Шинээр тохижуулсан амрах өрөө болон чийрэгжүүлэлтийн өрөө	10	12	20	Тайлант хугацаанд - Ачит эмнэлэг өргөтөл барьж засварлаж ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх чийрэгжүүлэлт болон амрах өрөө, гал тогооны өрөө засаж тохижуулсан байна. - 14 эрүүл мэндийн байгууллага шинээр үүсч байгууллага тус бүр

					ажилчдын амрах өрөөг тохижуулсан. - БОЭТ-ийн Дотрын тасгийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар засварлаж, ашиглалтад оруулсан. БОЭТ-ийн ажилчдыг ширээний теннис тоглох боломжоор хангасан.
14	Гэр болон түрээсийн орон сууцанд хамрагдсан эрүүл мэндийн ажилтны тоо	14	30	12	Эрүүл мэндийн салбарын нийт 14 ажилтан аймгийн ЗДТГ-аас түрээсийн орон сууцаар хангагдсан байгаа нь өмнөх оны мөн үеийн түвшинд байна. Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь үр бүтээлтэй олон жил ажиллаж байгаа 30 ажилтанд орон сууц худалдан авахад зориулан урьдчилгаа төлбөр тус бүр 20,0 сая төгрөг, Эрдэнэт сувилал орон сууц худалдан авсан нийт 6 ажилтанд тус бүр 13.0 сая төгрөгийн дэмжлэг, Эрдэнэт медиал эмнэлэг нь 3 албан хаагчид орон сууцны урьдчилгааг олгох эрхийн бичгийг тус тус олгосон.

Тус хөтөлбөрийн үр дүн:

- Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан хувь нийт эмч мэргэжилтний 12,9% байгаа нь өмнөх оноос 0,4%-аар нэмэгдсэн, төгсөлтийн дараах сургалтад хамруулахаар төлөвлөснөөс төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч мэргэжилтний эзлэх хувь 73% байна.
- Нийт 104 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн судалгаа шинжилгээний ажил хийж, 62 илтгэл эрдэм шинжилгээний хуралд тавьсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0,5%-аар өссөн үзүүлэлтэй байна.
- Эрүүл мэндийн салбар байгууллагуудын эмч, эрүүл мэндийн ажилтнуудаас боловсролын зэрэгтэй эмчийн эзлэх хувь 11.1% болж өмнөх оноос 0,1% аар нэмэгдсэн.
- Зөвлөх зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 12,5% ,тэргүүлэх зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 29,6%, ахлах зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн 44,4%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.
- Гадаад хэлний мэдлэгийн түвшин дээшлүүлсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний эзлэх 19,6%-д хүрч 1,2%-аар ахисан үзүүлэлттэй байна.
- БОЭТ нь ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нийгмийн баталгааг дэмжих зорилгоор шинээр орон сууц авах 30 ажилтанд 20,0 сая төгрөгийн урьдчилгаа олгогдсон.
- Эрүүл мэндийн салбарын ажилчдын 92% нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1%-аар өссөн байна. Эрүүл мэндийн төрийн байгууллагын 40-өөс дээш насны 330 ажилчдыг 7 төрлийн хавдрын маркерын шинжилгээнд хамруулсан.